

# Улсын их хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд



## Хураангуй

Шинээр байгуулагдсан Засгийн газраас 2025 оны 12 сарын 30-ны өдөр УИХ-д өргөн барьсан байсан татварын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг эргүүлэн татаж, шинээр боловсруулсан хуулийн төслүүдийг УИХ-д 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн барьсан. Эдгээр хуулийн төслүүдийг 2026 оны хаврын чуулганаар хэлэлцэж батлан, 2027 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөнө гэсэн хүлээлттэй байна.

Бид энэхүү татварын мэдээллээр шинэ хуулийн төслүүдэд тусгагдсан гол нэмэлт, өөрчлөлтүүд мөн өмнөх Засгийн газраас 2025 оны 12 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлж байсан төслөөс хасагдсан заалтуудын талаар хураангуй мэдээллийг хүргэж байна.



## 1. Татварын ерөнхий хуульд оруулах гол нэмэлт, өөрчлөлтүүд:

- Татвар төлөгч татварын хууль тогтоомжийг ямар хэмжээнд сахин биелүүлж буйг “Татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшин”-д үндэслэн тогтоох ба 100 хүртэл оноогоор үнэлэнэ. Түвшинг тогтоохдоо татвар төлөгчийн бүртгэл, тайлагнал, татвар ногдуулалт, төлөлт, гаргасан зөрчлийн мэдээлэл гэх мэт шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэх юм. Дээрх тоон утгад харгалзан татвар төлөгчдийг маш сайн, сайн, дунд, муу гэсэн ангилалд оруулна. Хууль даган мөрдөлтийн түвшнийг улирал, жилээр тодорхойлж, татвар төлөгчид татварын нэгдсэн системээр мэдэгдэнэ.
- Маргаан таслах зөвлөл, шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа нөхөн ногдуулалтын актаар ногдуулсан алданги, торгуулийг эцэслэгдэн шийдвэрлэгдэх хүртэл хугацаанд татвар төлөгчөөс нэхэмжлэхгүй.
- Татвар төлөгчийн банканд дахь дансыг битүүмжилж, ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар гаргуулах татварын өрийг хэмжээ нь тухайн орлогын 80 хувиас хэтрэхгүй байна. Битүүмжилсэн данснаас ногдол ашиг, харилцан хамаарал бүхий этгээдэд төлөх төлбөрийн болон өөрийн буруутай үйлдлээс үүсэн өр төлбөртэй холбоотой зарлагын гүйлгээ хийхийг хориглоно.
- Татвар төлөгчийн хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй татварт тооцох алдангийн нийт дүн нь хугацаандаа төлөөгүй татварын үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхээргүй байна.
- Татвар төлөгч татварын тайланг дараагийн хоёр татварын жилд багтаан залруулж болно.

Засгийн газраас эргүүлэн татсан 2025 оны 12 сарын 30-ний хуулийн төслийн дараах заалтууд хасагджээ.

- Татварын алба нь татвар төлөгчийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, татварын хууль тогтоомжийг сайн дураар даган мөрдөхөд дэмжин, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллана.
- Татварын маргаан таслах ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явуулах бөгөөд татвар төлөгчийн хүсэлтээр маргаан таслах зөвлөлийн хуралдааныг нээлттэй явуулж, олон нийтэд дуу-дүрсний бичлэгээр хүргэнэ.
- Татварын алба жишиг үнийн арга болон үнэ шилжилтийн тохируулга хийх арга, татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм ашиглан нөхөн ногдуулалтын акт үйлдсэн тохиолдолд тухайн арга, дүрэм ашигласан тухай тайлан, дүгнэлтийг нөхөн ногдуулалтын актад хавсаргана.
- Дотоод болон Ерөнхий үнэ шилжилтийн тайлангуудыг татварын албанд хүргүүлэх хугацааг дараа оны 6 сарын 30 болгон сунгана.

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.

## 2. ААНОАТ-ын хуульд оруулах гол нэмэлт, өөрчлөлтүүд

- Бизнесийн үйл ажиллагааны ашигт ногдуулах татварын ачаалалыг бууруулах зорилгоор одоогийн 2 шатлал хувь хэмжээг 3 болгон дараах байдлаар өөрчилнө:

Татвар ногдуулах орлогын жилийн дүн (төгрөг)	Татварын хувь хэмжээ
6 тэрбум хүртэлх дүнд	10%
6 тэрбумаас давсан 10 тэрбум хүртэлх дүнд	15%
10 тэрбумаас давсан дүнд	25%

- Доор дурдсан салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 2.5 тэрбум төгрөгөөс бага татвар ногдох орлоготой ААН-ийн татвар ногдуулах орлогод 10 хувиар татвар ногдуулж, эцсийн татварын тайлангаар ногдуулж, төлсөн татварыг 90 хувиар хөнгөлж, буцаан олгоно:
  - Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах;
  - Согтууруулах ундаа, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох;
  - Газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн.
- Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг хөнгөлөнө.
- Их хэмжээний өгөгдлийг өндөр хурдтай хадгалах, автоматаар боловсруулах зориулалттай тоног төхөөрөмж, график процессор бүхий сервер, супер компьютерын хувьд 3 жилийн хугацаанд ашиглах хөрөнгөд элэгдэл хорогдолыг тооцохоор тусгажээ.
- ААНОАТ-ын тайланг гаргаж, тайлагнах эцсийн хугацааг уртасгаж хагас жилийн тайлангийн хувьд тухайн жилийн 7 сарын сүүлийн өдөр, жилийн эцсийн тайлангийн хувьд дараа жилийн 2 сарын сүүлийн өдөр тус тус болгоно.



Засгийн газраас эргүүлэн татсан 2025 оны 12 сарын 30-ний хуулийн төслийн дараах заалтууд хасагджээ:

- Хялбаршуулсан горим ашиглах борлуулалтын орлогын одоогийн босго 50.0 сая төгрөгийг 400.0 сая болгон нэмэгдүүлэн өөрчилж, татвар ногдуулах орлогыг үйл ажиллагааны орлогын 10 хувиар тодорхойлж, 10 хувиар ААНОАТ ногдуулна.
- Ашигт малтмал, газрын тусгай зөвшөөрөл эзэмшигч нэмж хувьцаа гаргах замаар хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор эцсийн эзэмшигчийн хувь оролцоо, саналын эрхийн бүтэц өөрчлөгдсөн тохиолдолд эрх шилжүүлсэн гэж үзэхгүй.
- Өмнөх 12 сарын цалингийн зардлын нийт дүнгийн 10 хувиас хэтрэхгүй дүнтэй ажилтныг сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэхтэй холбоотой гарсан зардлыг, 5 хувиас хэтрэхгүй дүнтэй ажилтны хангамжийн зардлыг татвар ногдох орлогоос хасаж тооцож болно.
- Татвар ногдох орлогоос хасаж тооцох сайн дурын даатгалын хураамжийн зардлын дүнгийн хязгаарын дүнг нэмэгдүүлж, тухайн татварын жилийн албан татвар ногдуулах орлогын 2027 онд 20 хувиас, 2028 онд 25 хувиас, 2029 оноос эхлэн 30 хувиар хязгаарлана.

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.

### 3. НӨАТ-ын хуульд оруулах голлох нэмэлт, өөрчлөлтүүд

- Үйл ажиллагааны борлуулалтын орлого нь үргэлжилсэн 12 сарын хугацаанд 400 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн этгээд НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлнэ.
- Татварын скоринг (татвараа бүрэн төлсөн, хууль даган мөрдөлтийн түвшин) “сайн” буюу түүнээс дээш үнэлгээтэй бол хүсэлт гарган 1 сараар, төлөлт сайн бол мөн дахин 2 хүртэлх сарын хугацаанд сар бүр тэнцүү төлөлт хийж хойшлуулна (импортын бараанд төлсөн НӨАТ-д мөн адил хамаарна). Хойшлуулан төлөх татварын хэмжээ нь тухайн татвар төлөгчийн сүүлийн улиралд импортолсон ижил төрлийн бараанд төлсөн НӨАТ-ын сарын дунджаас хэтрэхгүй байна.

Засгийн газраас эргүүлэн татсан 2025 оны 12 сарын 30-ний хуулийн төслийн дараах заалтууд хасагджээ:

- ✗ Үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг шууд бүрэн хасна.
- ✗ Доор дурдсан салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, үргэлжилсэн 12 сарын хугацаанд 400 сая төгрөг хүртэлх үйл ажиллагааны борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж өөрийн хүсэлтээр татварын хялбаршуулсан горимд хамрагдаж болно: - ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах; - согтууруулах ундаа, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох; -газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа.
- ✗ Хялбаршуулсан горимтой татвар суутган төлөгч нь тухайн улиралд хийсэн борлуулалтынхаа дүнгийн 90%-тай тэнцэх хэмжээний худалдан авалт хийсэн гэж тооцон татвараа тодорхойлж, улирлаар тайлагнана. Улирлын тайлангаа дараагийн сарын 20-ны дотор цахимаар татварын албанд илгээнэ.
- ✗ ААНОАТ болон НӨАТ-ын зорилгоор борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрөх хугацааг адил болгож, борлуулалтын нэхэмжлэл, эсхүл төлбөрийн баримт үйлдсэнээр НӨАТ ногдуулна.
- ✗ НӨАТ суутган төлөгч оршин суугч бус этгээдээс худалдан авсан, төлбөрийг бэлэн бусаар гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнд ногдуулсан төлсөн НӨАТ-ыг хасна.
- ✗ НӨАТ суутган төлөгч оршин суугч, харилцан хамааралгүй этгээдээс НӨАТ-гүй худалдан авалт хийж төлбөр тооцоог бэлэн бусаар хийсэн бол төлбөрийн дүнд 10%-ийн НӨАТ шингэсэн гэж үзэн хасалт тооцож болно.
- ✗ Ёслол хүндэтгэлийн арга хэмжээ, ажилтны сургалт болон хувийн хэрэглээнд төлсөн НӨАТ-ын дүнгийн хувьд үргэлжилсэн 12 сарын цалингийн зардлын сарын дундажын 15 хувиас хэтрүүлэхгүй хасалт тооцож болно.



Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.

#### 4. ХХОАТ-ын хуульд оруулах голлох нэмэлт, өөрчлөлтүүд

- Хялбаршуулсан горим ашиглах үйл ажиллагааны орлогын босгыг 1 тэрбум болгож, татвар ногдуулах орлогыг үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр ХХОАТ ногдуулна.
- Татвар төлөгчийн хөдөлмөр эрхлэлтийн жилийн 9.5 сая хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах ХХОАТ-ыг бүрэн хөнгөлнө.
- Монгол Улсын иргэний үргэлжилсэн таваас доошгүй жилийн хугацаанд өмчилсөн бөгөөд өөрийн үндсэн оршин суух хаягт бүртгэлтэй амьдран суух зориулалттай орон сууцаа борлуулж олсон орлогыг ХХОАТ-аас чөлөөлнө.
- ХХОАТ-ын тайлагнал, төлөлтийг хялбарчилж, хугацааг дараа оны эцэс хүртэл сунгана.

Засгийн газраас эргүүлэн татсан 2025 оны 12 сарын 30-ний хуулийн төслийн дараах заалтууд хасагджээ:

- Хялбаршуулсан горим ашиглах үйл ажиллагааны орлогын босгыг 400.0 сая болгож, татвар ногдуулах орлогыг үйл ажиллагааны орлогын 10 хувиар тодорхойлж, 10 хувиар ХХОАТ ногдуулна.
- Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар орон сууц худалдан авах, барих, орон сууцны нөхцөл сайжруулахад зарцуулсан төлбөрийн баримтаар нотлогдох дараах зардлуудтай тэнцэх хэмжээний орлогод ногдох 15 сая төгрөг хүртэлх татварын хөнгөлөлтийг нэг удаа эдлүүлнэ. Үүнд:
  - Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын стандарт хангасан орон сууц худалдан авах, барихад зарцуулсан хөрөнгө;
  - Гэр хорооллын орон сууцны дулаан алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлт бий болгох нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур, дулааны насос худалдан авсан зардал;
  - Аймаг, сум, улсын зэрэглэлтэй хотын болон Нийслэл хотын дагуул хот, Багануур, Багахангай, Налайх дүүргийн хилийн цэсийн дотор анх удаа орон сууц худалдан авах, барихад зарцуулсан хөрөнгө.
- Татвар төлөгчийн албан татварыг тодорхойлох, ногдуулах, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах, үүсэж болзошгүй татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн МТА-наас ХХОАТ-ын төслийг урьдчилан боловсруулж, цахим татварын системээр татвар төлөгчид хүргүүлнэ. Татвар төлөгч шаардлагтай бол тайланд залруулга хийж болно.

#### Холбоо барих мэдээлэл:



**Серги Кобахидзе**

Партнер

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ

[sergi.kobakhidze@pwc.com](mailto:sergi.kobakhidze@pwc.com)



**Цэндмаа Чойжамц**

Захирал

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ

[tsendmaa.choijamts@pwc.com](mailto:tsendmaa.choijamts@pwc.com)



**Энхзул Жамбал**

Ахлах Менежер

Татварын зөвлөх үйлчилгээ

[enkhzul.jambal@pwc.com](mailto:enkhzul.jambal@pwc.com)



**Энхсанаа Эрдэнэ-Очир**

Ахлах Менежер

Татварын зөвлөх үйлчилгээ

[enkhsanaa.erdene-ochir@pwc.com](mailto:enkhsanaa.erdene-ochir@pwc.com)

**Та дээрх болон бусад асуудлаар татварын зөвлөх үйлчилгээ авахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу.**

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.